

**ГАМШГААС ХАМГААЛАХ БОДЛОГО, СТРАТЕГИ,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ОНОЛ,
АРГА ЗҮЙН АСУУДАЛ**
*“DISASTER PROTECTION POLICY, STRATEGY, AND THEORETICAL AND
METHODOLOGICAL ISSUES”*

*М.Өлзий-Оришх
ДХИС-ийн магистрант, ахмад*

Хураангуй:

Энэхүү өгүүлээр бодлого, стратеги, төлөвлөлтийн онолын үндсийг судалж тэдгээрийн ялгаатай болон хоорондын харилцан хамаарлыг ойлгох мөн эдгээр нэр томъёо нь Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хүрээнд хэрхэн ашиглагдаж байгааг харьцуулан судлахыг зорилоо.

Abstract:

This article aims to examine the theoretical foundations of policy, strategy, and planning, understand their differences and interrelationships, and compare and contrast how these terms are used in the context of disaster management.

Түлхүүр үг: Бодлого, стратеги, төлөвлөлт

Keywords: Policy, strategy, and planning

Оршил

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд бодлого, төлөвлөлт, стратеги нэр томъёог ихээхэн ашигладаг. Дан ганц гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд бус бүхий л үйл ажиллагааг зохион байгуулахад төлөвлөлт, стратеги, бодлогийн арга хэмжээг тусгах шаардлага бий болдог. Иймээс эдгээр үгсийн онолын үндэс болон гамшгаас хамгаалах үйл ажиллагааны бодлого, стратеги, төлөвлөлтийн байдлыг анхан шатны түвшинд хэрхэн ойлгох ухагдахууныг олж мэдэхийг зорьлоо.

Төлөвлөлт нь байгууллагын зорилго, зорилтыг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд материаллаг болон материаллаг бус нөөцийг хэрхэн хуваарилах, чухам юуг, яаж хийх, тэдгээрийн ажлын үр дүнг ямар үзүүлэлтээр дүгнэхийг нарийвчлан гаргах процесс юм. Энэхүү процессийн арга хэмжээг гамшгаас хамгаалах үйл ажиллагааны гамшгийн өмнөх үе шатанд бэлэн байдлыг хангах арга хэмжээнд төлөвлөлтийн хэрэгцээ шаардлага өндөр гэж үздэг. Гамшгаас хамгаалах төлөвлөлтийг хэрэгжүүлэх хамгийн оновчтой, үр

дүнтэй арга бол бүх шатны гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх үйл явц юм.

Стратеги бол байгууллагын зорилгодоо хүрэхийн тулд удирдлагын зүгээс авч байгаа арга хэмжээг тодорхойлдог бөгөөд онцгой байдлын байгууллагын хувьд “Онцгой байдлын байгууллагын стандарттай хөгжлийн стратеги 2030” баримт бичгийг батлан хэрэгжүүлж эхлээд байна.

Бодлого боловсруулахад асуудал болон бэрхшээлийг тодорхойлох үйл явцад анхаарлаа хандуулахаас гадна үр ашигтай шийдлийг эрж хайх, хийж гүйцэтгэхэд шаардлагатай хэрэгжилтийн шалгуурыг бий болгох зэрэг цогц үйл ажиллагааг шаарддаг.

Аливаа бодлогын мөн чанар нь засаглах шинж чанартай, албадах чадвартай, нийгэм, хүмүүсийн үйл ажиллагааг нэгэн зорилгод чиглүүлэх нөлөөтэй, тэдгээрийн нийтлэг хүсэл эрмэлзэл, ашиг сонирхол, хэрэгцээг хангахад чиглэсэн байна¹.

Тухайлбал:

№	Бодлого, түүний мөн чанар	Агуулга ба илэрхийлэл	Тайлбар
1	Бие биетэйгээ харилцан уялдаатай, бие биеэ нөхсөн, заавал биелэгдэх шинж зэргийг агуулсан мөн чанартай байна.	Амжилтад хүрэх, амжилтаа бататгах, засаглалыг хэрэгжүүлэх, бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа	Үйл ажиллагаа
2		Төрийг удирдах урлаг, төрийн засаглалын институтдийн тусламжтайгаар нийгмийг хөгжүүлэх удирдлагын талаар явуулж байгаа манлайлагчдын үйл ажиллагаа	Удирдлагын үйл ажиллагаа
3		Төрөл бүрийн ашиг сонирхлын нэгдэл дээр тулгуурласан нийгмийн амьдралыг зохион байгуулах арга барил ²	Зохион байгуулах арга барил

Дээрх бүгдээс дүгнэхэд бодлогын мөн чанар нь засаглах буюу удирдамжийн шинжтэй, нийгэм, хүмүүсийн үйл ажиллагааны чиглэл зорилгыг тодорхойлсон, тэдгээрийн нийтлэг ашиг, сонирхлыг хамгаалахад чиглэсэн, хэрэгжүүлэх механизмыг илэрхийлсэн байна.

¹ Даш, П. Алтангэрэл, Д нарын. Гамшгаас хамгаалах бодлого, стратеги., Уб., 2020. 27 дахь тал.

² <https://all-politologija.ru>

Үндсэн хэсэг:

Төлөвлөлтийн тухай үндсэн ойлголт

Байгууллагын хөгжлийн зорилго, зорилтууд нь тунхагын чанартай биш, тодорхой, биелэгдэхүйц, хамт олныг байх явдал нэн чухал юм. Өөрөөр

Төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах үйл явц болон тооцооны үндсэн дээр нөөцөд тулгуурлан, зорилгод уялдуулан гүйцэтгэж байгаа үйл ажиллагааны ерөнхий төлөв планыг төлөвлөлт гэж ойлгож болно.

хэлбэл хүмүүс чухам юу хийхээ мэдэж байх ёстой. Үүний тулд төлөвлөлт хийгддэг.³

Төлөвлөлт бол өнөөгийн байдал, хүрэх гэж хүсч буй байдал хоёрыг холбогч гүүр бөгөөд ажлыг зохион байгуулалттай болгох, үр дүнтэй, эрсдэл багатай байх аргыг олж тодорхойлох явдал юм гэж олон судлаачид үзжээ.

Бүдүүвч 1:Төлөвлөлтийг доорх шаардлагын үүднээс хийж гүйцэтгэдэг:

- тодорхой бус байдлыг бууруулах;

- зорилтуудыг нарийвчлан гаргах;

- үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах;

- хяналт шалгалт хийхэд хялбар болгох;

Төлөвлөлтийн зарчим:

Зарчим гэдэг нь нэгд, удирдлага болгох гол санаа, хоёрт, дагаж мөрдөх үндсэн дүрэм, гуравт, аливааг эхлэхэд гол үндэс болгогч зүйл юм. Зарчим гэдэг бол байгалын хууль юм.


Гамшгаас хамгаалах тухай хуулинд гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зарчмыг тусгасан байдаг. Гэхдээ гамшгаас хамгаалах төлөвлөлтөд баримтлах зарчим нь өөр ба төлөвлөлтийн онол аргай зүйд баримтлах зарчмыг удирдлага болгоно.

³ Цэдэв, П. Гамшгаас хамгаалах төлөвлөлт. Уб., 2020. 13 дахь тал

Удирдахуйн ухааны нэрт төлөөлөгчдийн нэг А.Файоль анх төлөвлөлтийн дөрвөн ерөнхий зарчмыг үндэслэн гаргаж ирсэн байна. Тэрээр үйлдвэр, аж ахуйн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө буюу программыг боловсруулахад зайлшгүй мөрдөх шаардлагатай дөрвөн ерөнхий зарчмыг нэгдсэн, нэгдмэл байх, тасралтгүй, уян хатан, тодорхой байх гэж тодорхойлсон байна.⁴


Төлөвлөлтийн төрлүүд ба түвшин: Төлөвлөлт нь бодит амьдралд хэрэгжихдээ дараах 8 төрлийг дамждаг байна.

Бүдүүвч 2: Төлөвлөлтийн 4-н зарчим:



1. Зорилго
2. Зорилт
3. Стратеги
4. Бодлого
5. Дүрэм
6. Ажлын горим, журам
7. Хөтөлбөр
8. Төсөв

Бүдүүвч 3: Төлөвлөлтийн үе шат:



⁴ Мөн тэнд. дам ишлэв. 24 дэх тал

Стратегийн тухай үндсэн ойлголт:

Стратеги хэмээх нэр томъёо нь цэргийн хэрэг төдийгүй бусад шинжлэх ухааны салбарт улам бүр түгэж, нийтлэг шинжтэй болжээ.

Анхдагч ойлголт нь: дайныг явуулах, удирдах урлаг; Цэргийн стратеги улс төр, цэргийн хүрээнд аль эрт НТӨ үеэс үүсэж хөгжсөн ч стратегийн байдал (статус), ойлголт агуулагын хувьд өнөөг хүртэл маргаан дагуулсан ярвигтай нэр томъёо хэвээр байгаа юм.

Хоёр дахь ойлголт нь: иргэний чиглэл дэх, тодорхой бус нөхцөл дэх үйл ажиллагааны төлөвлөгөө; эсвэл өрсөлдөгч, сөргөлдөгч хоёр талын үйлдэл, ажиллагааны үрээр бүрэлдэж буй болсон нөхцөлөөс хамаарч талуудын үйл ажиллагааны хэлбэр, агуулга, зорилго, зорилтыг тодотгон ажиллах ажиллагааны хувилбар. Өнөө үед, “стратеги” хэмээх нэр томъёо нь улс төр, эдийн засаг, бизнес, банк төдийгүй борлуулалт (маркетинг)-д хамааралтай нэр томъёо болжээ. Ямарч стратеги шинж чанар, диалектик хөгжлөөрөө нэгд, хэн нэг, ямар нэг юмын хүчтэй, нөлөөтэй үйлчлэлийн тухай; хоёрт, алс хэтийн нөлөөтэй, үйлчлэлтэй хэрэгсэл, арга замын тухай; гуравт, ирээдүйн хөдөлгөөнт чиглэлийн тухай асуудлыг өөртөө шингээж байна.

Гурав дахь нь: сэтгэлгээтэй холбогдох, үр дүнд хүрэх, туршлага технологийг бий болгоход чиглэсэн сэтгэлгээний дараалал, зарчим, цэгцэрсэн үзэл бодол, баримтлал; өнөөдрийг ирээдүйтэй холбох, ирээдүйг өнөөтэй холбон төсөөлөх сэтгэлгээ юм.

Энэ бүхнээс харахад , “стратеги” гэсэн нэр томъёо маань “урлаг”, “төлөвлөгөө”, “хувилбар”, “зарчим”, “үзэл баримтлал”, “сэтгэлгээ” гэсэн үгстэй холбогдож “цэргийн”, “дайны” гэсэн үгээ гээхэд хүрчээ. Иргэний шинжлэх ухаанд “стратеги” гэсэн нэр томъёо нь баттай байр суурийг эзэлдэг болоод байхад цэргийнхэн энэ нэр томъёог ашигласаар байгаа юм. “Стратеги” хэмээх нэр томъёо дангаараа том ойлголт, агуулгыг илэрхийлдэг.

“Стратеги” бол стратегийн зорилго, зорилт биш, стратегийн үр дүн биш, гагцхүү зорилгоос үр дүнд хүрэх ажиллагааны арга зам, хэрэгсэл, хүч, энергийн цогц нэгдлээр илэрхийлэгдэх ухагдахууныг илэрхийлэгч нэр томъёо юм. Улмаар “стратеги” шинжлэх ухааны категори болж, олон шинж чанар бүхий, ээдрээтэй ойлголтыг агуулдаг

Стратеги нь өргөн хүрээний асуудлыг урт удаан хугацаанд, нэн их нөөцтэй холбон авч үздэг учраас онцлог олон шинжийг өөртөө агуулдаг байна. Стратегийн эдгээр шинжийг зарим эрдэмтэн, стратеги судлаач нар

⁵таван “Р” шинжээр тодорхойлон гаргасан байдаг. Тэрээр, нэгд, стратеги нь зарчим (principle) тогтоосон шинжийг, хоёрт, төлөвлөгөө (plan)-ний шинжийг, гуравт, стратеги нь байрлал (position) эзлэх номлолын шинжийг, дөрөвт, стратеги нь цаг хугацааны хэтийн хандлагатай, ирээдүй (perspective)-д чиглэсэн шинжийг, тавд, стратеги нь уран арга, уян маневр (pace)-ыг хэрэглэх шинжийг тус тус агуулдаг гэжээ.

Бодлогын тухай үндсэн ойлголт:

Доктор Ц.Цолмон “Удирдахуйн үндэс” номондоо, “бодлого бол мөн л төлөвлөгөө юм гээд учир нь шийдвэр гаргах бодол санааг чиглүүлэх, ерөнхий томъёолол буюу гол ойлголт болдог” гэжээ.

Тэгэхээр бодлого нь зөвхөн томъёолол төдий биш, удирдах ажилтны үйл ажиллагаанаас урган гарч байдаг зүйл байна.

Бодлого нь ямарваа бэрхшээлийг хүндрэлтэй асуудал болохоос өмнө шийдвэрлэхэд дэм үзүүлж, жирийн нөхцөл байдалд бэрхшээл гарч ирэх бүр түүнд зориуд дүн шинжилгээ хийх шаардлагагүй болгож, бусад төлөвлөгөөнүүдийг нэг мөр болгодог. Ингэснээр удирдах ажилтанд эрх мэдлээ доод тушаалын хүмүүстээ шилжүүлэх боломж олгож байна. Бодлого бол зохион байгуулалтын бүх түвшинд байна. Үүнд байгууллагын гол бодлогоос эхлэн албад болон хамгийн бага нэгжийн эрх ашгийг илэрхийлсэн бодлого хүртэл байна.

Бодлого нь борлуулалт санхүү гэх мэт өрсөлдөөнийг давж гарахуйц шинэ бүтээгдэхүүн зураг төсөл зохиохтой холбоотой байж болно. Олон чиглэлээр бодлого гаргаж болно. Дээд сургууль төгсөгчдөөс хүний нөөцөө хангах, шинэ техник багаж, тоног төхөөрөмжөөр хангах, хамтын ажиллагааг сайжруулах, өндөр соёлтойгоор үйлчилгээ үзүүлэх гэх зэргээр байж болно. Бодлого шийдвэр гаргахтай холбоотойн зэрэгцээ зарим талаар бие даасан байдалтай байх нь зүйтэй.

Гамшгаас хамгаалах бодлогын тухайд:

Гамшгаас хамгаалах бодлогыг тодорхойлоход анхаарах нэг гол онцлог бол гамшиг нь улс орныг төдийгүй бүс нутгийг, тив, дэлхийг хамарч болдогоос гадна гамшгаас хамгаалах арга хэмжээ нь улс орны тогтвортой хөгжил, хүн амын аюулгүй байдлыг хангах нэг үндсэн нөхцөл болдог.⁶

⁵ Мөн тэнд. дам ишлэв. 31 дэх тал

⁶ Алтангэрэл, Д. Даш, П. Сэржмядаг, Д. Чимэдцэрэн, П. нарын. Гамшгаас хамгаалах бодлого, стратеги. Уб., 2020.

Гамшгаас хамгаалах бодлогыг тодорхойлохын тулд хууль эрх зүйн орчин, гамшгийн нөхцөл байдал, гамшгаас хамгаалах чадавх, эдийн засгийн хүчин чадал, дэлхий нийтийн чиг хандлага зэрэгт дүн шинжилгээ хийж тэргүүлэх чиглэлээ сонгох хэрэгтэй.

Иймд гамшгаас хамгаалах олон улсын механизмыг ашиглах талаар илүүтэй анхаарах шаардлагатай. Ийм механизмын хамгийн хүчтэй үр нөлөөтэй нь НҮБ-аас зохион байгуулдаг улс орны тогтвортой хөгжлийн асуудалд хамаарах гамшгаас хамгаалах болон уур амьсгалын эрсдэлийн удирдлагын хүрээнд Гамшгийн аюулыг бууруулах асуудлаар хуралддаг дэлхийн бага хурлууд юм. Уг бага хурлуудад засгийн газрын төлөөллөөс гадна:⁷

- Төрийн бус байгууллагууд,
- Иргэний нийгмийн байгууллагууд,
- Орон нутгийн засаг захиргааны төлөөлөл,
- Хувийн хэвшлийн төлөөлөгчид зэрэг төрөл мэргэжлийн хүмүүс дэлхийн өнцөг булан бүрээс ирж гамшгаас хамгаалах болон цаг уурын өөрчлөлтийг удирдах замаар тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн асуудлыг эрэмбэ дараатай хэлэлцэн оновчтой шийдвэрүүдийг гаргадаг.

Энэхүү шийдвэр нь гамшгаас хамгаалах талаар дэлхийн улс орнуудын гамшгаас хамгаалах бодлогын нэг үндэс нь болдог байна.

Гамшгаас хамгаалах удирдлага явуулахад бодлого хэрэгтэйгээс гадна эрх зүйн маш олон баримт бичгийг хэрэгжүүлэхийн тулд тэдгээрийн үзэл санааг хураангуйлж нэг үзэл санаанд нэгтгэдэг баримт бичиг нь бодлого мөн юм. Ийм учраас эрх зүйн болон удирдлагын олон бичиг баримтын үзэл санааг нэгтгэхэд бодлого болон бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөх

Гамшгаас хамгаалах стратегийн онолын үндэс:

Гамшиг нь дэлхий дээр амьдрал үүссэн тэр цагаас эхлэн хүн төрөлхтний амь нас, ахуй амьдралд сөрөгөөр нөлөөлж хор хохирол учруулсаар ирсэн. Түүхийн бүхий л цаг үед хувь хүмүүс төдийгүй нийгэм бүхэлдээ аливаа гамшгаас урьдчилан сэргийлэх, түүнд өртөж хохирохгүй

⁷ Алтангэрэл, Д. Даш, П. Сэржмядаг, Д. Чимэдцэрэн, П. нарын. Гамшгаас хамгаалах бодлого, стратеги. Уб., 2020. 32 дахь тал

байх, өөрсдийгөө хамгаалах төрөл бүрийн арга ухааныг буюу стратегийг ашиглаж байсан түүхэн эх сурвалжуудад тэмдэглэгдэн үлдсэн байдаг.

Аливаа гамшгийг бий болгож буй учир, шалтгаан, хүчин зүйлүүдийг илүү сайн ойлгох практик хэрэгцээ болон гамшгаас хамгаалах үйл ажиллагааны онол, аргазүйн үндсийг оновчтой тодорхойлох шинжлэх ухааны шаардлагын үүднээс гамшгаас хамгалах стратегийн агуулгыг тодорхойлохын өмнө хэд хэдэн суурь ойлголтын талаар нэгдсэн хандлага бий болгох нь чухал ач холбогдолтой байх болно.

Гамшгаас хамгаалах стратегийн онол, аргазүйн үндсийг тодорхойлоход гамшиг ба гамшгаас хамгаалах гэсэн хоёр үндсэн ухагдахуун, тэдгээрийн хэрэглээний ойлголтын мөн чанар, харилцан хамаарлыг авч үзэх шаардлагатай юм.

“Гамшгаас хамгаалах стратеги бол хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчныг байгалийн болон хүний хүчин зүйлээс үүдсэн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, эрэн хайх, аврах, хойшлуулашгүй сэргээн босгох үйл ажиллагааг хэрэгжүүлэн хамгаалж, улс орны тогтвортой хөгжил, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн өргөн хүрээний асуудлыг хамгийн үр дүнтэй, үр ашигтай байдлаар төлөвлөх, зохион байгуулах онол, арга ухаан ба удирдлагын ажиллагаа” байна.

Орчин үеийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааны стратеги нь байнга өөрчлөгдөж байгаа гамшиг ослын цагийн байдал, улс төр, эдийн засгийн тогтворгүй байдал, гамшигтай тэмцэх техник, технологи, арга барилын хөгжил, дэвшлээс хамаарч үйл ажиллагааны хамрах хүрээ, боловсруулах хугацаа зэргээрээ өргөн цар хүрээтэй, далайцтай болсоноороо онцлог юм. Энэ нь удирдлагын төрөл бүрийн эсвэл тэдгээрийн нийлмэл стратегийг шаарддаг.⁸

Гамшгаас хамгаалах стратегийн төлөвлөлт:

Стратегийн төлөвлөлт бол удирдлагын бүх чиг үүргийг хамардагийн хувьд стратегийн удирдлагыг хэрэгжүүлэх үндсэн механизмын нэг болдог.⁹ Энэ утгаараа стратегийн төлөвлөлтийн үйл явц нь удирдлагын шийдвэр гаргахад тусалдаг нэн чухал хэрэгсэл болдог бөгөөд түүний үндсэн зорилт нь шинэчлэл, өөрчлөлтийг бий болгоход оршино.

⁸ Алтангэрэл, Д. Даш, П. Сэржмядаг, Д. Чимэдцэрэн, П. нарын. Гамшгаас хамгаалах бодлого, стратеги. Уб., 2020. 152 дахь тал

⁹ Мөн тэнд. Дам ишлэв. 162 дахь тал

Стратегийн төлөвлөлт нь дараах үндсэн үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Төлөвлөгөө боловсруулах стратегийн урьдчилсан үнэлгээ хийх
- Стратегийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах
- Стратегийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулах
- Стратегийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг чиглүүлэх
- Стратегийн төлөвлөгөөний үр дүнд хүргэх үндэслэлийг гаргах
- Стратегийг биелүүлэх үйл явц, биелэлт, үр дүнд хяналт, үнэлгээ өгөх

Гамшгаас хамгаалах стратегийн төлөвлөлт нь стратегийг боловсруулахад харгалзан үзэх өнөөгийн байдлын болон хэтийн төлөвийн урьдчилсан үнэлгээг хийх, гамшгаас хамгаалах асуудлыг хөгжүүлэх зорилго, арга замыг тодорхойлж, нөөцүүдийг хуваарилж, зохион байгуулах, улам төгөлдөржүүлэх асуудлыг хамаарах удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа хоёрын нэгдлийг агуулсан үйл явц байна.

Гамшгаас хамгаалах төлөвлөлтийн тухайд:

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны гамшгийн өмнөх үе шатанд урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд төрийн болон бүх нийтийн бэлэн байдлыг хангах асуудалыг хамруулан авч үздэг.

Бүх нийтийн бэлэн байдлыг хангахын тулд иргэдийн гамшгийн талаарх ойлголт мэдлэгийг дээшлүүлэх, буруу зан төлвийг өөрчлөх замаар түлхүү анхаардаг. Эдгээр нь гамшгийн эрсдэлийг бууруулах бүтцийн арга хэмжээнд багтдаг.

Төрийн бэлэн байдлыг хангахад гамшгаас хамгаалах төлөвлөлтийн үзүүлэх нөлөөлөл их байдаг.

Гамшгаас хамгаалах төлөвлөлтийг хийх хамгийн оновчтой арга хэлбэр бол бүх түвшинд Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулах явдал юм.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг засаг захиргааны бүх түвшинд хийх шаардлагатай бөгөөд орон нутгийн болон аж ахуйн нэгж, байгууллагын төлөвлөгөөнд гамшгаас хамгаалах шуурхай арга хэмжээнүүдийг тусгаж, эдгээр үйл ажиллагаанд оролцогч талуудын хамтын ажиллагааг нарийвчлан тусгах хэрэгцээ шаардлага байдаг.

Гамшигийн үед нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэх тул тухайн цаг мөчид оролцогч талууд хэрхэн ажиллах талаар дэлгэрэнгүй тусгасан удирдлагын баримт бичиг нь гамшгаас хамгаалах төлөвлөгөө юм.

Монгол орны хувьд байгалийн гамшиг бусад улс орнуудтай харьцуулахад тохиолдол болон тоо давтамжийн хувьд бага учираас өмнөх төлөвлөлтийн сул болон дутагдалтай талыг олоход ихээхэн хүндрэлтэй. Харин одоо хэрэгжиж буй эрх зүйн орчны хүрээнд бүх шатны байгууллага болон аймаг, нийслэл, сум, дүүрэг, улсын албадын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хяналт тавьж үнэлгээ хийх хэрэгцээ шаардлага байсаар байна.

Хүснэгт 1: Бодлого, стратеги, төлөвлөлтийн тухай үндсэн ойлголт ба гамшгаас хамгаалах үйл ажиллагааны бодлого, стратеги, төлөвлөлтийн шинж чанар

Бодлого	Стратеги	Төлөвлөлт
Бодлого гэж Засгийн газар бүрэн эрхийнхээ хугацаанд болон шаардлагатай тохиолдолд тодорхой асуудлыг шийдвэрлэх зорилгоор гаргасан улс төрийн шийдэл, үйл ажиллагааны чиглэлийг хэлнэ	“Стратеги” бол стратегийн зорилго, зорилт биш, стратегийн үр дүн биш, гагцхүү зорилгоос үр дүнд хүрэх ажиллагааны арга зам, хэрэгсэл, хүч, энергийн цогц нэгдлээр илэрхийлэгдэх ухагдахууныг илэрхийлэгч нэр томъёо юм.	Төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах үйл явц болон тооцооны үндсэн дээр нөөцөд тулгуурлан, зорилгод уялдуулан гүйцэтгэж байгаа үйл ажиллагааны ерөнхий төлөв планыг төлөвлөлт гэж ойлгож болно.
Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хүрээнд:		
Гамшгаас хамгаалах удирдлага явуулахад бодлого хэрэгтэйгээс гадна эрх зүйн маш олон баримт бичгийг хэрэгжүүлэхийн тулд тэдгээрийн үзэл санааг хураангуйлж нэг үзэл санаанд нэгтгэдэг баримт бичиг нь бодлого мөн юм.	Гамшгаас хамгаалах стратеги бол хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчныг байгалийн болон хүний хүчин зүйлээс үүдсэн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, эрэн хайх, аврах, хойшлуулашгүй сэргээн босгох үйл ажиллагааг хэрэгжүүлэн хамгаалж, улс орны тогтвортой хөгжил, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн өргөн хүрээний асуудлыг хамгийн үр дүнтэй, үр ашигтай байдлаар төлөвлөх, зохион байгуулах онол, арга ухаан ба удирдлагын ажиллагаа” байна.	Гамшгаас хамгаалах төлөвлөлтийг хийх хамгийн оновчтой арга хэлбэр бол бүх түвшинд Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулах явдал юм. Төрийн бэлэн байдлыг хангахад гамшгаас хамгаалах төлөвлөлтийн ач холбогдол маш өндөр.

Дээрх хүснэгтээс харахад бодлого, стратеги, төлөвлөлтийн үндсэн ойлголт тэдгээрийг гамшгаас хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулахад хэрхэн ашиглаж байгааг цөөн үгээр товч ойлгож болно.

Дүгнэлт:

Бодлого болон стратеги нь өөр хоорондоо шууд харилцан хамааралтай ойлголтууд юм. Аль нэгийг нь дангаар нь авч үзэх боломжгүй ойлголтууд юм.

Автомашинаар бол урд болон хойд дугуй гэж ойлгож болно. Хойноо хөтлөгчтэй автомашины хувьд урд дугуй нь бодлого, хойд дугуй нь стратеги болно.

Ямар төрлийн чиглэлийг баримталж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг бодлогод тусгасан байдаг бол стратеги нь тухайн бодлогийг ямар түвшинд, хэрхэн хэрэгжүүлэх талаар тусгасан цогц арга хэмжээ хэмээн ойлгож болно.

Бүх л улс гамшгаас хамгаалах бодлого, стратеги, төлөвлөлтийг өөрийн улс орны онцлогт нийцүүлэн хэрэгжүүлж байдаг. Сүүлийн жилүүдэд бүс нутгуудын гамшгаас хамгаалах бодлого болон НҮБ-ийн гишүүн орнуудын гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр баримталж буй бодлого хэрэгжиж байна. Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн III-р бага хурлаар батлан гаргасан “Сендайн үйл ажиллагааны хүрээ” бодлогийн баримт бичгийг монгол улсад хэрэгжүүлэх урт болон дунд хугацааны стратеги гаран одоо хэрэгжиж байна.

Төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах үйл явцыг төлөвлөлт гэж ойлгож болно. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төлөвлөлтийг гамшгийн өмнөх үе шатанд бэлэн байдлыг хангах арга хэмжээний хүрээнд хамруулан авч үздэг.

Гамшгаас хамгаалах төлөвлөлтийг сайжруулах хамгийн оновчтой арга нь бүх шатны гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих явдал юм.

Бодлого, стратеги, төлөвлөлтийн тухайд өөр хоорондоо харилцан хамаарал бүхий нэг нь нөгөөдөө багтаж байдаг ач холбогдол бүхий зохион байгуулалтын баримт бичгүүд юм.

Санал:

- Бүх шатны ажилтан, алба хаагч нар өдөр тутмын үйл ажиллагаандаа тухайн цаг үед нийцэн гарсан бодлого, стратегийн баримт бичгийг мөрдлөг болгон төлөвлөгөө боловсруулж ажиллах хэрэгцээ шаардлага өндөр байна.

Ашигласан материал:

- Гамшгаас хамгаалах тухай хууль, 2020 он
- Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичиг
- Д.Сэржмядаг, Гамшгаас хамгаалах менежметийн үндэс, Уб, 2017 он
- П. Цэдэв, Гамшгаас хамгаалах төлөвлөлт, Уб, 2020 он
- Д.Алтангэрэл, П.Даш, Д.Сэржмядаг, П.Чимэдцэрэн нарын Гамшгаас хамгаалах бодлого, стратеги, Уб, 2020 он